



УЛСЫН ГАЗАРЗҮЙН 29-Р ОЛИМПИАД

12 дугаар анги





Даалгавар 1. Байрзүйн зургийг (Зураг 1) ашиглан даалгаврыг гүйцэтгэнэ үү.

Хариултыг хүснэгтэд (Хүснэгт 1) бичээрэй. (Нийт 6 оноо)

А) Зургийн тоон болон нэрлэсэн масштабыг тодорхойлно уу.

В) 300л/ц ус гаргах хүчин чадалтай өрөмдмөл худгийн газарзүйн болон тэгш өнцгийн солбицлыг олоорой


С) Зурагт тэмдэглэгдсэн Сүүж булаг байрлах цэгийн өндөр болон түүнээс Алаг уул (1136.6) хүртэлх шулуун зайг(м) тус тус тодорхойлно уу

Д) Улиасан ойн хажууд байрлах тоонуудыг тайлбарлан бичнэ үү

Хүснэгт 1.

Асуулт	Хариулт
А) Зургийн тоон болон нэрлэсэн масштаб	
В) 300л/ц ус гаргах хүчин чадалтай өрөмдмөл худгийн газарзүйн болон тэгш өнцгийн солбицол	
С) Сүүж булаг байрлах цэгийн өндөр болон түүнээс Алаг уул (1136.6) хүртэлх шулуун зайг(м) тус тус тодорхойл	
Д) Улиасны ойн хажууд байрлах тоонуудыг тайлбарлан бич (12, 0.30, 3)	

Даалгавар 2. 2024 оны 7 дугаар сарын 2 дугаар 10 хоногийн гангын төлөв байдлаас Монгол орны байгалийн аль бүс бүслүүр ганд илүү өртсөнийг тайлбарлан бичнэ үү (Нийт 3 оноо)



Даалгавар 3. Хорин минутын хот гэдэг концепц нь 20 минутын дотор алхаж очоод төрийн үйлчилгээ авах, хүүхдээ цэцэрлэг сургуульд нь хүргэж, өгөх авах боломж бүхий бодлогын шийдэл бөгөөд дэлхийн 100 гаруй хотод хэрэгжиж байна. (нийт 3 оноо)



- А) Хан-Уул дүүргийн хэддүгээр хороо ерөнхий боловсролын сургуульгүй вэ?
- В) Ногоон өнгөөр тэмдэглэсэн Б сурагч 20 минутын дотор алхаж очих боломжтой сургуулийг нэрлэнэ үү?
- С) Ногоон өнгөөр тэмдэглэсэн А сурагч 20 минутын дотор алхаж очих боломжтой сургуулийг нэрлэнэ үү?

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

Даалгавар 4. Германы Эрфурт хотод байрладаг Улаанбаатар гудамжны уртыг олно уу? (Нийт 2 оноо)



Даалгавар 5. Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас нэг хүнд ногдох ногоон байгууламжийн талбайг 9м^2 -аас багагүй байна гэж тодорхойлсон байдаг. Доорх газрын зургуудад 9100 оюутантай Монгол Улсын Их Сургуулийн хичээлийн 2-р байр болон 4188 оюутантай Япон улсын Гифү Их Сургуулийн хичээлийн байрууд дүрслэгдсэн бол дараах даалгаврыг гүйцэтгэнэ үү. (Нийт 6 оноо)



- А) Их сургууль тус бүрийн ногоон байгууламжийн талбайг олно уу
 Б) Нэг оюутанд ногдох ногоон байгууламжийн талбайг сургууль тус бүрээр олно уу



Зураг а. МУИС хичээлийн 2-р байр

Зураг б. Гифү Их Сургуулийн хичээлийн байрууд

Бодолт:.....

Даалгавар 6. Хөрсний дээжийг ашиглан дараах дараах даалгаврыг гүйцэтгээрэй.
(Нийт 10 оноо)

А) Хөрсний дээж дээр давсны хүчил дусааж (HCL 10%) илрэх урвалыг ажиглаарай. Урвалын тэгшитгэлийг бичиж тайлбарлаарай.

Б. Дараах алхмын дагуу хөрсний механик бүрэлдэхүүнийг тодорхойлоорой.

Алхам 1. Хөрсний дээжээс бага хэмжээтэй авч усаар зуурна. Зуурсан хөрсийг алганы хооронд шахах, эсвэл базахад ус дусахгүй, гоожихгүй байхаар зуурна. Түүнчлэн хэт аргуу, хатуу бол тохиромжгүй.

Алхам 2. Зуурсан дээжийг хоёр гарынхаа алганы завсар бөөрөнхийлж бөмбөлөг хэлбэртэй болгоно.

Алхам 3. Бөмбөлөг болсон зуурмагийг хуруугаар 3 см орчим голчтой болтол нь нарийсгаж элдэнэ (Зураг хар).

Алхам 5. Нарийсган элдсэн хөрсөөр цагариг хийнэ.

Алхам 6. Хөрсний гурвалжныг ашиглан нэрлээрэй

